



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 04

Баянтал сум

Төсөл сонгон шалгаруулах тов тогтоох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хоршооны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.2, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 2.10, 2.11, 2.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төсөл сонгон шалгаруулах товыг 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 21-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулахаар товлосугай.

2.Тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавин ажиллаж, үр дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг сумын Засаг дарга (Э.Баттулга)-д даалгасугай.

ДАРГА

Б.МӨНХ-ЭРДЭНЭ